



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ АВЛИГЫН
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ

2025 ОНЫ САРЫН ӨДӨР

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн суурь түвшин	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.	Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх Эрх зүйн үндэслэл: - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5, 7.6.1, 7.6.2; - Авлигын эсрэг хуулийн 5.1.2; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.5; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.2.	1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаархи мэдээллийг албан хаагчид, иргэд чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар 2024 онд 2 удаагийн сургалт зохион байгуулж, 100 албан хаагчийг хамруулсан.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар 2025 онд 2 удаагийн сургалт зохион байгуулж, 150 албан хаагчийг хамруулах.	2025.01.01-12.31	ТЗУГ-ХХ /Эрх бүхий албан тушаалтан/
		1.2. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг АТГ-тай хамтран зохион байгуулах.	Авлигатай тэмцэх газраас 2024 онд 1 удаагийн сургалт зохион байгуулсан.	Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 онд 2 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/ /АТГ/
		1.3. Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг	шударга байдлыг нэмэгдүүлэх талаар 2024 онд 1	Шударга байдлын үнэлгээг яам, харьяа байгууллагын бүх албан хаагчдад танилцуулах	2025.01.01-12.31	ТЗУГ /хүний нөөц хариуцсан Ахлах шинжээч/

		зохион байгуулж, үнэлгээ танилцуулах.	удаагийн сургалт зохион байгуулсан.	сургалт 1 удаа зохион байгуулах.2 сургалт, хэлэлцүүлэг, зохион байгуулна.		
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.2; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.5.	2.1. Иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх 2.2. Яамнаас санаачлан боловсруулж байгаа хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх. 2.3. Зам, тээврийн яамнаас хуулийн этгээдтэй байгуулж буй бүх гэрээнд авлигын эсрэг заалт оруулах.	Яамны цахим хуудас, олон нийттэй харилцах онлайн мэдээлэл хүлээн авах буланд 2024 онд 103 мэдээлэл, санал ирсэн. 2024 онд Хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн 2 төсөлд цахим хуудсанд байршуулсан санал авсан. 2024 онд 526 гэрээнд авлигын эсрэг заалт оруулсан.	Яамны цахим хуудас, олон нийттэй харилцах онлайн мэдээлэл хүлээн авах булангаар 2025 онд мэдээлэл хүлээн авна. 2025 онд Хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн 2 төсөлд санал авсан байна. 2025 оны бүх гэрээнд тухайн заалтыг оруулна.	2025.01.01-12.31	АЗБХЗГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АТБХЗХ, ТЗУГ /хуулийн мэргэжилтнүүд/
3.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.3 - Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.17;	3.1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах. 3.2. Хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд	Хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөөг 2024.03.26-ны өдөр цахим хуудсанд байршуулсан. 2024 онд 385 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, хуулийн	Хяналт шалгалтын 2025 төлөвлөгөөг 2025.06.01-ний өдрийн дотор цахим хуудсанд байршуулна. 2025 онд 472 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж, хуулийн хугацаанд олон нийтэд	2025.01.01-06.01 2025.01.01-12.31	СХГ СХГ

		цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	хугацаанд олон нийтэд мэдээлсэн.	дүнг нээлттэй мэдээлсэн байна.		
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаар/ Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.4; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.2, 8.4.3 дугаар зүйл	4.1. 2025 оны төсөв, 2025 оны болон улирал, сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг яамны цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх.		Байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
		4.2. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, уг дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэх		Байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
		4.3. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/		Байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
		4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлэх		Байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
		4.5. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл		Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
		4.6. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх		Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн тоо	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/

		4.7. Төсвийн төслийн талаар яам болон харьяа байгууллагын хэмжээнд хэлэлцүүлэг явуулж, нэгж байгууллага, албан хаагчдын саналыг авч тусгах		Төсвийн төслийн талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусгасан байна.	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /холбогдох албан тушаалтнууд/
5.	Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.5; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл	5.1. Эрсдэлтэй байгууллагын жагсаалтыг гаргаж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулсан байх.	2024 онд 2 харьяа байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийсэн.	Зам, тээврийн яамны харьяа 3 байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн байна.	2025.01.01-12.31	ХШУДАГ /холбогдох албан тушаалтан/
		5.2. Байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсанд шинэчлэн байршуулах	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан	Олон нийтэд 2025.06.01-ний өдрийн дотор 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зөвшөөрөл, гэрчилгээ авсан аж ахуй нэгжийн жагсаалтыг шинэчлэн байршуулсан байна.	2025.01.01-06.01	БТГ-МТХ /холбогдох албан тушаалтнууд/
		5.3. Зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд шинэчлэн байршуулах	Шаардлагатай мэдээллийг бүрэн байршуулсан	Зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг 2025.06.01-ний дотор цахим хуудсанд байршуулах.	2025.01.01-06.01	БТГ-МТХ /холбогдох албан тушаалтнууд/

6.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.5; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл	6.1. Сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.	Сул орон тооны 7 зарыг тухай бүр байршуулж олон нийтэд хүргэсэн.	Сул орон тооны зарыг тухай цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.	2025.01.01-12.31	ТЗУГ /хүний нөөц хариуцсан Ахлах шинжээч/
		6.2. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг нээлттэй болгох	2024 онд 51 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг нээлттэй мэдээлсэн.	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг тухай бүр нээлттэй цахим хуудсанд байршуулна.	2025.01.01-12.31	ТЗУГ /хүний нөөц хариуцсан Ахлах шинжээч/ Эрх бүхий албан тушаалтан /
7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.4; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл	7.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах	Төлөвлөгөөг батлуулж, цахим хуудсанд байршуулсан.	Төлөвлөгөөг батлуулж, 2025.06.01-ний өдрийн дотор цахим хуудсанд байршуулсан байна.	2025.01.01-06.01	ТЗУГ, СХ /худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/
		7.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах.	2024 онд 7 тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулсан.	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	2025.01.01-12.31	
		7.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон	Холбогдох мэдээллийг холбогдох этгээдэд	Холбогдох мэдээллийг холбогдох этгээдэд бүрэн, шуурхай мэдээлсэн байна.	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /худалдан авах ажиллагаа

	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47.4, 48.5	шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг холбогдох этгээдэд мэдээлэх	бүрэн, шуурхай мэдээлсэн.			хариуцсан мэргэжилтэн/
		7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулсан байна.	Олон нийтэд хэрэгцээтэй мэдээллийг ойлгомжтой байдлаар байршуулна.	2025.01.01-12.31	
		7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах	Аудитын тайлан, дүгнэлт, шалгалтын дүнг бүрэн байршуулсан.	Аудитын тайлан, дүгнэлт, шалгалтын дүнг бүрэн байршуулсан байна.	2025.01.01-12.31	ТЗУГ, СХ /худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/
8.	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх Эрх зүйн үндэслэл: - - Авлигын эсрэг хуулийн 6.1.9, 6.8, 6.1.6;	8.1. Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх.	Тогтмол утас ажиллуулах, цахим хуудас, шуудан, биечлэн, хайрцаг байршуулах зэрэг хэлбэрээр мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн	Зам, тээврийн салбартай холбоотой зөрчил мэдээллийг хүлээн авах тусгай суваг бий болгоно.	2025.01.01-12.31	ТЗУГ, ХХ /хуулийн мэргэжилтэн/
		8.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр арга хэмжээ авах		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ бодитой болсон байна.	2025.01.01-12.31	ТЗУГ, ХШУДАГ

	- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;	8.3. Албан хаагчдын давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг судлан шийдвэрлэх, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа гаргах	2024 оны Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, давхар ажил эрхэлж буй 2 албан хаагчийн мэдээллийг АТГ-т хүргүүлсэн.	Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулж, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай болсон байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /хүний нөөц хариуцсан Ахлах шинжээч/
9.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3;	9.1. Яамны дэргэдэх авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлтэй хамтран ажиллах.	Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулхаар ажиллаж байна.	Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө батална. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувиас дээш хэрэгжүүлнэ.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/

10.	Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.11; - Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7.8, 7.9, 19.3;	10.1. Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх	2024 онд нийт 843 өргөдөл гомдол, санал, хүсэлтийг утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар зэрэг хэлбэрээр хүлээн авсан.	2025 онд Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар зэрэг хэлбэрээр хүлээн авах боломжтой болсон байна. Хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлнэ.	2025.01.01-12.31	ТЗУГ /өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн/
11.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах Эрх зүйн үндэслэл: - Авлигын эсрэг хуулийн 6.1.12; - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1	11.1. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах.	Зам, тээврийн салбарын авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтны судалгааг болосвруулсан.	Зам, тээврийн салбарын авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтны судалгааг гаргаж, тухай албан хаагчид чиглэсэн 1 үйл ажиллагаа явуулсан байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/
		11.2. Албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаанд нь гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох	2024 онд ХОМ-ийг хугацаанд нь гаргаагүй албан хаагч байхгүй.	Албан тушаалд томилогдсон албан хаагчийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж хэвшүүлсэн байна. Албан тушаалтнаар тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн	2025.01.01-12.31 2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/

		Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө албан тушаалтнаар тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвшүүлэх		мэдэгдэл гаргаж хэвшүүлсэн байна.		
		11.3. Салбарын харьяа байгууллагуудад Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх	2024 онд Харьяа 2 байгууллагад Авлигын эрсдэлийн үнэлгээ хийлгэхээр албан бичиг хүргүүлсэн.	Харьяа 2 байгууллагад Авлигын эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/
12.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх - Эрх зүйн үндэслэл Авлигын эсрэг хуулийн 6.6, 6.7, 18.4.2, 29.4; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2:	12.1. АТГ-ын мөрдөгчөөс гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдлийн дагуу холбогдох арга хэмжээ авах	2024 онд АТГ-ын мөрдөгчөөс гэмт хэргийн нотлох баримт авах тухай 6 албан бичиг ирүүлсэн.	Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн суурь шалтгаан, нөхцөлийг бүрэн арилгах арга хэмжээ авч, үр дүн гаргасан байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/
		12.2. Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	2024 онд АТГ-аас хүчингүй болгох талаар мэдэгдэл ирээгүй.	Холбогдох дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох	2025.01.01-12.31	ТЗУГ, ХХ /хуулийн мэргэжилтэн/

				асуудлыг судлан шийдвэрлэсэн байна.		
		12.3. Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан.	Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжийн талаар судалгаа хийсэн.	Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг 2025.06.01-ний өдрийн дотор гаргаж батлуулсан байна.	2025.01.01-12.31	БТГ
13.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	13.1. Салбарын төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт хэрэгжүүлэх	Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулхаар ажиллаж байна.	Олон нийтийн хяналтын дэд зөвлөл Зам, тээврийн салбарын төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох зөвлөмж өгсөн байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/
		13.2. Зам, тээврийн салбарын авлигын эрсдэлийг бууруулах орон тооны бус зөвлөл байгуулах	Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулхаар ажиллаж байна.	Зам, тээврийн салбарын авлигын эрсдэлийг бууруулах орон тооны бус зөвлөл байгуулагдаж, салбарын хэмжээнд авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулагдсан байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/
14.	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах	14.1. Яамны болон харьяа агентлаг, газруудын цахим хуудасны хөгжүүлэлт, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, цахим хуудаст байршуулж буй мэдээллийг Англи, Монгол хэл дээр бүрэн нийтэлдэг болох	Яамны болон харьяа агентлаг, газруудын цахим хуудасны 12 мэдээллийг мэдээллийг Англи хэл дээр бүрэн нийтэлсэн.	Яамны болон харьяа агентлаг, газруудын цахим хуудасны хөгжүүлэлт, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах ажилд шалгалт хийж, мэдээллийг Англи,	2025.01.01-12.31	БТГ-МТС, ТЗУГ-ГХАХ

				Монгол хэл дээр бүрэн нийтэлдэг болсон байна.		
		14.2. Зам, тээврийн салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчилсан бүрэн хэмжээний контент хийх.	2024 онд Бүрэн хэмжээний 1 контент хийсэн.	Бүрэн хэмжээний контент 2 хийсэн байна.	2025.01.01-12.31	ТЗУГ /Эрх бүхий албан тушаалтан/ БТГ-МТС
		14.3. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн үйл ажиллагааг ил тод болгох.	АТГ-тай хамтран явцын хяналтыг төлөвлөлгөөг бэлтгэж байна.	АТГ-тай хамтран явцын хяналтыг хийх.	2025.04.01-2025.12.01	АЗБЗГ, /Эрх бүхий албан тушаалтан/ АТГ
2025 онд хэрэгжих мега төслүүдэд ажлын төсөв, санхүү, зарцуулалт, гүйцэтгэлд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	14.4. Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох.	MNS70232023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж байна.	MNS70232023 "Мэдээллийн самбар"-т тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.		2025.04.01-2025.12.01	/Эрх бүхий албан тушаалтан/ АТГ